

**ГХБХБГ-ЫН 2 ДУГААР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,  
СУДАЛГАА**

2018.02.08.

**ӨЛГИЙ СУМ**

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ долоо хоногт ГХБХБГ-ын 2017 онд бүтэн жилийн хийсэн ажлаа аймгийн ЗДТГазарт тайлагнасан болно.</p> <p>Газрын цахим бирж ажиллуулах тухай ажлыг аймгийн хэмжээний бүх сумуудад нэвтрүүлсэн. Мөн Алтай, Улаанхус сумуудад ажил хэрэг болгосон.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. <b>Тухайлбал:</b></p> <p><b>Өлгий сум:</b> 2 иргэнд шинээр газар эзэмших, 2 иргэний эзэмших газрын хэмжээг өмчлөх тухай 2 удаа захирамж гаргуулсан.</p> <p>Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх тухай 3 иргэнд мөн 25 иргэнд үнэт цаасаар газрын кадастрын үйлчилгээ үзүүлсэн. 10 хүнд газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж, ЛМ програмд оруулж, Улсын бүртгэлд бүртгэв.</p> <p><b>Алтай сум:</b> Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.</p> <p><b>Алтанцөгц сум:</b> 7 иргэний өвөлжөөний нэгж талбарын кадастрын өөрчлөлтийг дуусган ЛМ-д холбож иргэний хувийн хэргийг сканердаж оруулав.</p> <p>ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтнээр 9 иргэний өвөлжөөний газрын нэгж талбарын кадастрын өөрчлөлтийг дуусгаж өгөв.</p> <p>3 иргэнд үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлж өгөв.</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

2 иргэнд хадлангийн гэрээ байгуулав.

2 иргэнд гэрээ хийж,гэрчилгээ олгов

Газрын төлбөр цуглуулав.

**Бугат сум:** 10 хүний өргөдөл хүлээн авсан. 3 хүнд кадастрын зураг гаргаж өгөв. 1 иргэний газараа өвлүүлэн авсан материалыг00 бүрдүүлж, эрхийн шилжүүлэн кадастрын зураг гаргаж өгөв. Газрын төлбөрт 45000 төгрөг оруулав. 4 хүний өргөдлийг авч 1 иргэнд кадастрын зураг гаргасан. 3 иргэний үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлж өгөв.1иргэний нэгж талбарын хувийн хэрэг бүрдүүлэв

**Ногооннуур сум:** Шинээр газар эзэмшүүлэх 11 захирамж Газар эзэмших хугацааг сунгах 1 захирамж гаргаж, гэрээ хийж, гэрчилгээ олгосон.

**Толбо сум:** Шинээр газар эзэмшигч иргэдэд гэрчилгээ олгож, Улсын бүртгэлд бүртгэв.

**Дэлүүн сумын** төв болох 9-р багын 13 өрхийн өмчлөлийн газарт захиалга өгч, Өлгий Ланд ХХКомпанид кадастрын зураглал хийлгэж ЛМ програмд оруулж,Улсын бүртгэлд бүртгэж бүртгэсэн.

**Цэнгэл сум:** Аймаг, сумын Засаг даргын 3 захирамж гаргуулсан. Үүнд газар эзэмшүүлэх тухай 2 иргэнд 1400м2, 1 иргэнд газар эзэмшүүлэх эрх шилжих захирамж, 11 иргэнд 8159м2 газрыг тус тус өмчлөлд олгох захирамж гаргуулав. Мөн 10 өргөдөл хүлээн авч цаг тухайд шийдвэрлэж хариу өгөв. Өмчилсөн газрын талбайд өөрчлөлт оруулах тухай нэг захирамж гаргуулав. Тус сумын 2, 4-р багийн ИНХ-д оролцож зарим малчдын дунд үүссэн бэлчээрийн маргааныг газар нь очиж шийдвэрлэж ирэв.

## ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР